



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. Газрын тосны үнэ нэмэгдсэнээр S&P 500 индексийн сагсанд багтдаг эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өсөв. "Amazon, com" компани онлайн эмийн сангийн үйлчилгээ үзүүлэгч "Pillpack" компанийг худалдан авах болсонтой холбогдуулан эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцааны ханш унажээ.

АНУ-ын Засгийн газар БНХАУ-аас АНУ-ын мэдээлэл технологийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалтыг хязгаарлахаар төлөвлөж байгаа талаар мэдээлсэн бол Европын Холбооноос тогтоосон гаалийн татвартай холбоотойгоор "Harley-Davidson" компани зарим мотоциклын үйлдвэрээ АНУ-ын хилээс гаргахаар шийдвэрлэсэн нь зах зээлд сөрөг нөлөө үзүүлжээ.

АНУ-ын газрын тосны нөөц багасан, тус улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар 11-р сараас өмнө Иран улсаас нийлүүлдэг газрын тосны экспортыг бүрэн зогсоох талаар мэдээлсэн нь газрын тосны үнэ өсөх гол шалтгаан болжээ. Газрын тосны ханш өссөнөөр тус түүхий эдийг ашигладаг салбарын компаниудын хувьцааны ханш унаж эхэлсэн байна. АНУ-ын Төв банкнаас жил бүр явуулдаг "Стресс тест"-д 35 банк бүгдээрээ тэнцэж, эдийн засгийн гүн хямрал тохиосон ч тэсвэрлэх чадвартай гэдгээ баталсан нь санхүүгийн салбарын компаниудын хувьцааны ханшид эерэг нөлөө үзүүлжээ.

**Европ:** Худалдааны маргааны тодорхой бус байдлаас шалтгаалан Европын компаниудын хувьцааны ханш унав. Авто машин үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш унасан бол эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өсжээ.

Газрын тосны үнэ өссөнөөр Европын бүсийн өнөөгийн инфляцийн түвшин Төв банкны зорилтот түвшнээс хэтэрсэн байна. Инфляцийн үндсэн үзүүлэлт 2 хувьд хүрчээ. Харин Европын төв банкны инфляцийн зорилтот түвшин 2%-аас доогуур байхаар тусгасан байв.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. Иений ханш ам.долларын эсрэг суларч, 110.7 нэгж хүрсэн нь 2017 оны сүүлчээс 1.7%-аар чангарсан байна.

5-р сард Японы улсын ажилгүйдлийн түвшин 1992 оноос хойшхи хамгийн доод түвшин болох 2.2 хувьд хүрчээ.

Япон улсын томоохон аж үйлдвэрийн хот болох Осакад болсон томоохон газар хөдлөлт тус улсын эдийн засагт 183.5 тэрбум иений хохирол учруулсан хэмээн мэдэгдлээ.

**БНХАУ:** Худалдааны маргаан БНХАУ-ын компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлсөн хэвээр байна.

БНХАУ-ын Төв банк заавал байлгах нөөцийн харьцаагаа 0.5 хувиар бууруулах шийдвэр гаргаж буйгаа мэдэгдлээ. Энэ шийдвэр нь банкуудын зээл олголтыг дэмжин, тус улсын эдийн засаг 100 тэрбум ам.доллараар тэлнэ хэмээн үзэж байна.

БНХАУ-ын эдийн засаг удааширч, заавал байлгах нөөцийн хувь бууран, юанийн ханш суларчээ.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,961.46	2.14% ▲
Dow Jones	АНУ	24,271.41	-1.26% ▼
S&P 500	АНУ	2,718.37	-1.33% ▼
Nasdaq	АНУ	7,510.30	-2.37% ▼
S&P/TSX	Канад	16,277.73	-1.05% ▼
FTSE 100	Их Британи	7,636.93	-0.59% ▼
S&P/ASX 200	Австрали	6,194.60	-0.49% ▼
Nikkei 225	Япон	22,304.51	-0.94% ▼
Hang Seng	Хонг Конг	28,955.11	-1.31% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	107.46
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	94.76
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	93.80
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	111.78
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.02
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.59
TDBM' 2020	USD	9.3%	105.41

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.030	-0.07 ▼
Libor 3M	2.336	0.00 ▼
Libor 6M	2.501	-0.01 ▼
Libor 1YR	2.764	-0.01 ▼
US 6M Bond	2.102	0.02 ▲
US 2YR Bond	2.516	-0.01 ▼
US 3YR Bond	2.608	-0.01 ▼
US 5YR Bond	2.719	-0.02 ▼
US 10YR Bond	2.838	-0.03 ▼

### Валютын ханш /төг/

Валют	2018.06.29	Өөрчлөлт
USD	2,462.82	0.36% ▲
CNY	371.78	-1.56% ▼
EUR	2,862.66	0.11% ▲
RUB	39.21	1.00% ▲
KRW	2.21	-0.45% ▼
JPY	22.26	-0.09% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,250.72	-1.38% ▼
Мөнгө /spot/	16.05	-1.95% ▼
Зэс	296.90	-2.88% ▼
Нүүрс	111.33	3.80% ▲
WTI газрын тос	73.18	7.00% ▲
Brent газрын тос	78.13	5.27% ▲
Байгалийн хий	2.91	-0.34% ▼

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. V	6.10%
Бодлогын хүү	2018. V	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. V	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. V	12.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. V	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. V	18.70%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. V	10.10%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 51 компанийн 2,953.9 сая төгрөгийн 14,738,343 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хөвсгөл алтан дуулга” /ADU/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсч 247.45 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол секюритиес” /MSC/ компанийн хувьцаа 27.69%-аар буурч 470 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 1,904 ширхэг үнэт цаас 196 сая төгрөгөөр арилжаалагджээ.


6-р сарын 29-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,481.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,961.46 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.14%-аар өссөн байна.

## MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	3,149.9
Зах зээлийн үнэлгээ	2,481,879.4

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,961.46	2.14% ▲
MSE I индекс	9,823.90	3.14% ▲
MSE II индекс	9,633.86	0.31% ▲

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	1,881,271	1,208,991,305
Хөх ган	5,152,102	437,973,720
Э-Транс ложистикс	5,119,779	435,176,799
БиДиСек	401,956	401,984,800
Эрдэнэ Ресурс	154,279	101,019,349
Девелопмент Корп.		

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл алтан дуулга	247.45	15.00% ▲
Хархорин	1,600.00	14.29% ▲
Хөх ган	95.00	11.76% ▲
Фронттиер лэнд групп	320.00	10.34% ▲
АПУ	633.39	9.64% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол секюритиес	470.00	-27.69% ▼
Бэрх Уул	730.00	-14.12% ▼
Агротехимпекс	1,075.00	-13.10% ▼
Бинсэ	350.00	-13.04% ▼
Дархан зочид буудал	144.00	-7.10% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	2,868,820,996
Бумбат-Алтай	1,602,994,926
Голомт капитал	486,975,975
Гендекс	142,307,332
Стандарт инвестмент	94,829,084

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	633.39	674,042
Таван толгой	9,655.00	508,483
МИК	11,000.00	227,803
Говь	24,020.00	187,383
Сүү	215.00	73,690

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	27	2,700,000	100,000	100,000	104	14.820%
2	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	113	11,300,000	100,000	100,000	104	14.820%
3	ZGEB-BD-09/05/19-A0242-15.995	201	20,100,000	100,000	100,000	104	15.995%
4	ZGEB-BD-11/04/19-A0230-18	1,000	105,150,000	105,150	105,150	104	18.000%
5	ZGEB-BD-14/02/19-A0208-18	64	6,400,000	100,000	100,000	104	18.000%
6	ZGEB-BD-14/03/19-A0219-18	200	20,440,000	102,200	102,200	104	18.000%
7	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	240	24,000,000	100,000	100,000	156	15.140%
8	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	59	5,896,460	99,940	99,940	104	13.955%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
23	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаан 6-р сарын 29-ны өдөр боллоо

“МИК актив арван зургаа” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус компанийн гаргаж буй ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй хугацаагаар олгож, 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 30 хүртэл жилийн хугацаатай, орон сууцны зээлээр баталгаажсан нийт 1,170,673 ширхэг баталгаат үнэт цаасыг нь бүртгэлээ. Баталгаат үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэрээр Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаан оролцогч, үүрэг гүйцэтгүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч нарт тогтмол хяналт тавьж, ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зориулалт, ашиглалтын тайлан мэдээг Хороонд ирүүлж байх, тус зах зээлийг зохистой хөгжүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөв.

Түүнчлэн Хороо, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргах энгийн хувьцааг бүртгэх тухай асуудлыг хэлэлцэж, нийтэд санал болгон нэмж гаргах нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4.4 сая ширхэг хувьцааг бүртгэн, нийт гаргасан хувьцааг 15.7 сая ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орууллаа. Компани нэмж гаргаж буй хувьцааныхаа 3.3 сая ширхэгийг тогтоосон үнийн аргаар нэг бүрийг нь 850 төгрөгөөр төгрөгөөр стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх 1.1 сая ширхэгийг олон нийтэд мөн үнээр худалдахаар төлөвлөснийг зөвшөөрөв.

**Эх сурвалж:** Санхүүгийн зохицуулах хороо

### “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үнэт цаасны арилжааг зогсоолоо

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэмж хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн бөгөөд нэмж хувьцаа гаргах хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэнтэй холбогдуулан үнэт цаасны арилжааг 2018 оны 6-р сарын 29-ний өдрөөс эхлэн зогсоолоо.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Адуунчулуун” ХК болон “Могойн гол” ХК-ийн 2017 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Могойн гол” ХК-ийн 2017 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 100 төгрөг (татварын дараа 90 төгрөг) тараасныг болон “Адуунчулуун” ХК-ийн 2017 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 130 төгрөг (татварын дараа 117 төгрөг) тараасныг 2018 оны 6-р сарын 26-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**Эх сурвалж:** Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв



### “Сүү Бонд”-ын эргэн төлөлт хийгдлээ

МХБ-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК нь 2017 оны 6-р сарын 29-ний өдөр “Сүү Бонд”-ыг МХБ-ээр дамжуулан арилжаалж олон нийтээс 6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь МХБ-ийн түүхэн дэх хамгийн өндөр дүнтэй компанийн өрийн хэрэгсэл болсон билээ.

Тус өрийн хэрэгслийг “Сүү” ХК нь өөрийн хувьцаагаар баталгаажуулан гаргасан бөгөөд жилийн 17.5 хувийн хүүтэй буюу банкны хадгаламжаас өндөр өгөөжтэй байсан нь хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлснээс гадна олон ААН-үүдэд бага зардлаар өөрсдийн бизнесийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой болохыг харуулж чадсан юм. Мөн “Сүү бонд” нь хоёрдогч зах зээл дээр идэвхтэй арилжаалагдаж, өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийт 4.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Өнөөдөр “Сүү” ХК нь бонд эзэмшигчдийнхээ дансанд бондын эргэн төлөлтийг хүүгийн хамтаар байршуулснаар хөрөнгө оруулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ 100% биелүүлж, МХБ-тэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний үр дүнг дүгнэлээ.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### Сүүлийн 3 жилд 7 компани хөрөнгийн заххаас 60.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлжээ

Сүүлийн гурван жилийн хугацаанд хөрөнгийн заххаас нийт долоон компани 60.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлээд байна. Харин 2005 оноос хойш 20 компани 116.6 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ. Компани хувьцаагаа анх олон нийтэд санал болгохдоо эсвэл нэмж хувьцаа гаргахдаа татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг танилцуулдаг. Харин санхүүжилт татсаны дараа ТУЗ-ийн хурлаар энэ төлөвлөгөөгөө шинэчлэн баталдаг байна. Өөрөөр хэлбэл олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсний дараа ямар нэг шалтгаанаар төсөл хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэхүү хөрөнгийн зарцуулалтыг дахин шинэчлэх боломжтой юм.

Өнгөрсөн хугацаанд Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс санхүүжилт татсан компаниудаас “Монгол шуудан” компаниас өөр зөрчил гаргасан компани байхгүй гэж мэдээллээ. “Монгол шуудан” компани 2015 онд нэмж хувьцаа гаргаж, 6.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн боловч үүнийг зориулалтын бусаар зарцуулсан учир Санхүүгийн зохицуулах хороо торгууль тавьж байжээ.

Компаниудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг мэргэжлийн байгууллагууд тогтмол шалгадаг. Ялангуяа хөрөнгийн захад шинээр бүртгүүлсэн компаниудын тайлагнал сайн байгааг Монголын Хөрөнгийн бирж онцолж байна. Тухайлбал, Дархан хотод модульар дата төв байгуулахаар 1.3 тэрбум төгрөг олон нийтээс татан төвлөрүүлсэн “Ай түүлс” компанийн барилгын ажил дуусаж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд сар орчмын хугацаа үлдээд байгааг мэдээллээ.

Мөн “Анд энерги” компани шинэ үйлдвэрийнхээ ажлыг энэ сард эхлүүлээд байна. Ингэснээр энэ оны наймдугаар сарын 10-нд барилгын ажлаа дуусгаж, үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэхээр зорьж байгаа юм.

Үүнээс гадна “ЛэндМН” компани татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн 12 хувийг зээлийн үйл ажиллагаандаа ашиглаж, 1 улиралд 475 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Энэ нь 2017 оны нийт ашгаас 20 дахин өссөн үзүүлэлт болсон байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Steppe Gold: “Алтан цагаан овоо” төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх зөвшөөрлөө авсан

Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Steppe Gold” компани “Алтан Цагаан Овоо” төслийн явцын талаар мэдээллээ. Тус компани төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх газрын зөвшөөрлөө авсан байна.

Мөн Монголын тэргүүлэгч оператор компаниудтай хамтран ажиллахаар болсон төдийгүй замын бүтээн байгуулалт болон олборлолтын ажлын бэлтгэлээ хангаж эхэлж байгаагаа мэдээлэв. Энэхүү мэдээллийн дараа тус компанийн хувьцааны ханш 11 хувиар өссөн байна.

“Steppe Gold” компани тавдугаар сард Торонтогийн Хөрөнгийн биржид IPO гаргаж, 25 сая канад доллар татан төвлөрүүлжээ. Хэдий тийм боловч арилжаагаа эхэлснээс хойш хувьцааных нь ханш 38 хувиар буурсан байна.

Тус компани Монгол дахь Алтан Цагаан Овоо орддоо энэ онд 20 мянган метрийн өрөмдлөг хийхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ онд багтаан анхны олборлолтоо эхлэхээр зорьж байгаа ажээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### БНХАУ-ын антрацит нүүрсний импорт V сард 40 хувиар өсжээ

БНХАУ-ын коксжих нүүрсний импорт тавдугаар сард 2017 оны мөн үеэс 30.75 хувиар, дөрөвдүгээр сараас 33.9 хувиар өсөж, 6.08 сая тонн болсон байна.

Ялангуяа антрацит нүүрсний импорт жилийн өмнөхөөс 40 хувиар өсөж, 910 мянган тонн болсон талаар БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар мэдээллээ. Харин хүрэн нүүрсний импорт 7.5 хувиар өсөж, 7.93 сая тонн болсон байна.

Монгол Улсын хувьд оны эхний таван сард 14.31 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд энэ нь 2017 оны мөн үеэс таван хувиар буурсан талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Харин нүүрсний гарц тавдугаар сард 5.5 хувиар өсөж, 4.36 сая тонн болсон байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх тухай” УИХ-ын тогтоолыг батлав

УИХ-ын хаврын ээлжит чуулган баасан гарагт хаалтаа хийлээ. Хаалтын хуралдааны үеэр Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаарх авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж, 83.1 хувийн дэмжлэгтэйгээр баталлаа.

УИХ-ын гишүүн З.Нарантуяа, Д.Эрдэнэбат нарын оруулж ирсэн “Эрдэнэс Монгол ХХК-ийн 34 хувийг нийт иргэдэд эзэмших, нийтийн өмчлөлийн компани болгон өөрчлөн зохион байгуулах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх” гэсэн саналыг УИХ дахь МАН-ын бүлгийн гишүүд эсэргүүцэж, дэмжсэнгүй.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### Газрын тос боловсруулах үйлдвэртэй болсноор дотоодын хэрэгцээний 70 хувийг хангана

Дорноговь аймгийн Алтанширээ суманд Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг албан ёсоор эхлүүлээ. Одоогоор Монгол Улсын шатахууны импортын дөрөвний нэг орчмыг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна. Шатахууны хангамж цэвэр ОХУ-аас хамааралтай гэхэд болохоор байгаа юм. Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор валютын гарах урсгал 20 орчин хувиар буурч, дотоодын нийт бүтээгдэхүүн 10 хувиар нэмэгдэнэ гэж ажлын хэсэг тооцоолжээ.

Газрын тосны үйлдвэр ашиглалтад орсноор жил бүр ойролцоогоор 150 сая ам.долларын нэмэлт татвар төвлөрч, 600 гаруй ажлын байр бий болох цаашид хими, хуванцрын жижиг үйлдвэрлэл хөгжих суурь нөхцөл бүрдэх төлөвтэй байна. Үйлдвэр хөрөнгө оруулалтаа 10 жилд нөхөх ба гол санхүүгийн асуудлуудыг шийдсэн гэдгийг Ерөнхий сайд У.Хүрэлсүх үйлдвэрийн нээлт дээр онцоллоо. Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яамны мэдээлснээр Газрын тос боловсруулах үйлдвэр нь дотоодын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээний 70 орчим хувийг хангах хүчин чадалтай ажээ. Газрын тос боловсруулах үйлдвэрээс гадна дэд бүтцийн томоохон ажил, дагалдах төсөл хэрэгжихээр төлөвлөсөн байна. Хамгийн том ажил нь үйлдвэртэй холбох 500 км урттай дамжуулах шугамын бүтээн байгуулалт байгаа юм. Энэтхэгийн талаас гаргасан эхний ТЭЗҮ-д 600 гаруй сая ам.доллараар бүтнэ гэж тооцоолж байсан ч хэлэлцээрийн дүнд 350 сая ам.долларт багтаах боломжтой болсон гэж Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдээллээ.

Гол түүхий эдийг Тамсагийн сав газраас татна гэж тооцоод байгаа бөгөөд илрээд байгаа ашиглалтын баталгаат нөөц 43 сая тонноор хэмжигдэж байгаа аж. Өөрөөр хэлбэл өнөөгийн нөөцөд тулгуурлан боловсруулах үйлдвэр 40 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулна. “Цаашид хайгуулын ажил хийгдэж нөөцийн хэмжээ нэмэгдэнэ” гэдгийг Ерөнхий сайд У.Хүрэлсүх сайд онцолсон юм.

Үйлдвэртэй холбосон 27 км төмөр зам тавигдах бөгөөд төмөр замын ажлыг “УБТЗ” ХНН хариуцан гүйцэтгэж, 2019 оны 10-р сард дуусгахаар төлөвлөөд байгаа аж. Мөн 6.3 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станц, 18 км агаарын шугам татах юм. Бүтээн байгуулалтууд нь боловсруулах үйлдвэрээс гадна Дорноговь аймгийн хэрэгцээг хангахад ашиглагдах ажээ. Түүнчлэн 16 км хүнд даацын авто зам тавина гэж салбарын яамнаас мэдээллээ. Дагалдах дэд бүтцийн бүтээн байгуулалтууд 2019 онд дуусна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## БУСАД МЭДЭЭ

### Монгол улсын Засгийн газрын гаргасан “Дим Сам” бондын хугацаа 6-р сарын 30-нд дууслаа

2015 онд Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээлд юаниар гаргаж байсан “Дим Сам” бондын хугацаа 6-р сарын 30-нд дууслаа. Хоёрдогч зах зээлд “Дим Сам” бондын үнэ ханш 100 ам.доллар орчимд хэлбэлзэж байгаа нь он гарснаас хойш 0.6 хувиар буурсан дүн болжээ. Хоёрдогч зах зээлээс худалдан авагчдын шаардах өгөөж зургаадугаар сар гарсаар дээд түвшинд хүрч 10 хувь даваад байсан бол сүүлийн хөдөлгөөнөөр найман хувьтай байв. Шаардах өгөөж өндөр байх тусам хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг эрсдэлтэй гэж үзэж байгааг илэрхийлдэг. Харин хоёрдогч зах зээлд худалдах сонирхолтой хөрөнгө оруулагчдын санал болгож буй өгөөжийн түвшин -11.5 хувьтай байна.

“Дим Сам” бондыг анх 7.5 хувийн хүүтэй гаргаж байв. Өнгөрсөн онд Монгол Улсын Засгийн газар олон улсын зах зээлд “Гэрэгэ” бонд гаргаж 800 сая ам.долларын санхүүжилт татсан бөгөөд энэхүү бондын санхүүжилтээр “Дим Сам” бондын 160 гаруй сая ам.долларын эргэн төлөлтийг хийж гүйцэтгэхээр болсон юм.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатарын мэдээлснээр 6-р сард нийт 750 тэрбум төгрөгийн өр даржээ. Үүнээс 620 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт, 130 тэрбум төгрөгийг зээлийн хүүгийн төлбөрт төллөө.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Инфляцид нөлөөлөх хүчин зүйлүүд

Инфляцид нэг удаагийн болон нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлийн нөлөө их байна. Нөгөө талаас импортын барааны үнийн өсөлтийн хурд саарч байна гэж Монголбанк мэдээллээ. I улиралд инфляци хүлээгдэж байснаас бага зэрэг өндөр гарсан нь хатуу түлшний үнийн өсөлттэй холбоотой байсан байна. Цаашид эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор эрэлтийн шалтгаантай инфляци нэмэгдэх хүлээлттэй байгаа аж. Хэдий тийм боловч инфляци ирэх онуудад харьцангуй тогтвортой байж, зорилтот түвшний орчимд хадгалагдана гэж зургаадугаар сарын инфляцийн төлөв байдлын тайланд онцолжээ. Тавдугаар сарын байдлаар Улаанбаатар хотын инфляци 6.6 хувь, улсын инфляци 6.1 хувьтай байна. 2018 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцийг найман хувь орчимд тогтворжуулах зорилтыг Монголбанк тавьсан юм. Инфляцийн төлөв байдал тодорхой бус байдал үүсгэж буй хүчин зүйлсээр Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ, цаг агаарын нөхцөл байдал, Төрийн албан хаагчдын цалин нэмэх асуудал зэргийг нэрлэсэн байна. Харин гадаад талаас БНХАУ, АНУ-ын худалдааны маргаан, ОХУ-ын эдийн засаг болон газрын тосны үнийн өсөлт, геополитикийн асуудлууд тодорхой бус байдал үүсгэж байгааг Монголбанк онцолж байгаа юм.

Мөн 2019 онд уул уурхайн бус салбарын идэвхжилтэй холбоотойгоор хүнсний бус инфляци 2018 оны түвшнээс бага зэрэг өснө гэж үзжээ. Үүнээс гадна хүнсний инфляци бага зэрэг буурах төсөөлөлтэй байгааг зургаадугаар сарын инфляцийн төлөв байдлын тайланд дурдсан байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Банкнудын ААН-үүдэд олгосон зээл өмнөх улирлаас 500 гаруй тэрбум төгрөгөөр өсжээ

Арилжааны банкнудын аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл энэ оны I улирлаас хойш долоон хувиар өсөж, тавдугаар сарын байдлаар долоон их наяд 434 тэрбум төгрөгт хүрээд байна.

Энэ нь өмнөх сараас 300 гаруй, өмнөх улирлаас 500 гаруй тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Монголбанкнаас бизнесийн зээлийг тэлэх бодлого баримталж байна. Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр өсөн нэмэгдэж буй хэрэглээний зээлийг хязгаарлахын тулд иргэдийн өр/орлогын харьцаанд 70 хувийн дээд хязгаар тогтоосон юм. Энэ нь мөнгөний урсгалыг бизнесүүдэд чиглүүлнэ гэж Мөнгөний бодлогын хорооны гишүүд мэдээллээ.

Харин Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2.5 тэрбум төгрөгт хүргэх бодлого барьж байна. Зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнээр хүү 0.7 нэгж хувиар буурсан гэж Санхүүгийн зохицуулах хороо мэдэгдлээ. Компаниуд арилжааны банкнудаас санхүүжилт татахаас гадна хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломж нэмэгдэж байгаа аж.

2017 онд “Ай түүлс”, “Анд энерги” компаниуд хөрөнгийн зах зээлээс 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилт татаж байсан юм. Харин он гарснаар хөрөнгийн зах зээлээс “ЛэндМН”, “Монгол базальт” компани нийт 11.4 тэрбум төгрөгийг татжээ. Энэ нь 2017 оны нийт дүнгээс бараг тав дахин нэмэгдсэн үзүүлэлт болж байна.

Компаниудын хөрөнгийн зах зээлээс татсан санхүүжилт цаашид нэмэгдэх боломжтой бөгөөд учир нь энэ оны сүүлийн хагаст 4-5 компани IPO хийхээр материалаа бүрдүүлж байгаа ажээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### ОУВС дөрөв дэх шатны санхүүжилтийг Монгол Улсад олгохоор шийдвэрлэв

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” -ийн дөрөв дэх шатны үнэлгээг баталгаажуулж, дараагийн үе тутмын санхүүжилтийг Монгол Улсад олгохоор Олон Улсын Валютын Сангийн Захирлуудын зөвлөл шийдвэрлэлээ. Энэ удаад 36.9 сая ам.долларын санхүүжилтийг шийдвэрлэсэнээр “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсад олгохоор баталсан санхүүжилтийн хэмжээ 184.5 сая ам.долларт хүрээд байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийн өсөлт эрчимжиж, хөтөлбөрийн гол зорилтууд болох төсөв, санхүүгийн болон валютын нөөцийн төлөвлөсөн зорилтот түвшнийг давуулан биелүүлсэн гэж Олон Улсын Валютын Сангийн Захирлуудын зөвлөлийн дүгнэлтэд тусгасан байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээжгүй болно.